



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 22 өдөр

Дугаар А/166

Улаанбаатар хот

Аргачлал батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6, 5.7, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, 30.1.19-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хяналтын хуудас боловсруулах аргачлал"-ыг нэгдүгээр, "Хяналтын хуудас боловсруулах ерөнхий загвар"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү аргачлалын дагуу гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын хуудсыг боловсруулж, батлуулахыг Гамшгийн шуурхай удирдлагын газар (хурандаа Б.Мандахгэрэл), Гал түймэртэй тэмцэх газар (хурандаа Ц.Нямбаяр)-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА,  
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Г.АРИУНБУЯН



00002784

g:\2022\1\_2-r ulraftushaal-2022-1\_2.docx

Онцгой байдлын ерөнхий газрын даргын  
2022 оны 6 дугаар сарын 14-ны өдрийн  
#116.6 тушаалын нэгдүгээр хэсэрт



## ХЯНАЛТЫН ХУУДАС БОЛОВСРУУЛАХ АРГАЧЛАЛ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү аргачлалын зорилго нь Онцгой байдлын байгууллагын гамшгаас

хамгаалах болон гал түймрийн улсын хяналт шалгалт /цаашид "хяналт шалгалт" гэх/-ын хяналтын хуудас боловсруулах, батлуулах асуудлыг зохицуулах, ажлын хэсгийг арга зүйгээр хангахад оршино.

1.2. Онцгой байдлын байгууллагаас хяналт, шалгалтыг үр дүнтэй, ил тод, нээлттэй болгох, аливаа нөлөөллөөс ангид, адил тэгш, хараат бусаар хэрэгжүүлэх, тухайн байгууллагын хууль сахин мөрдөлтийн түвшин, эрсдэл үүсэх магадлалыг тодорхойлох зорилгоор хяналтын хуудсыг боловсруулж, хяналт шалгалтад хэрэглэнэ.

1.3. Хяналтын хуудсыг боловсруулах ажлыг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын тушаалаар томилогдсон ажлын хэсэг боловсруулах ба бус, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын байцаагч нарын оролцоог хангаж ажиллана.

1.4. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллага нь хяналтын хуудсыг иргэн, хуулийн этгээдэд сурталчилж, ил тод, нээлттэй байх нөхцлийг бүрдүүлнэ.

1.5. Хяналтын хуудасны бүрэлдэхүүн хэсэг, түүнд тусгагдсан асуудлаар нэмэлт зөвлөмж, заавар гаргаж болно.

Хоёр. Хяналтын хуудасны бүтэц, хяналтын хуудсанд тавих шаардлага, боловсруулах аргачлал

2.1. Хяналтын хуудасны бүтэц. Үүнд:

2.1.1. хяналтын хуудас нь "Ерөнхий мэдээлэл", "Тусгай тэмдэглэл", "Хяналт шалгалтын асуултууд, үнэлгээ", "Баталгаажуулалт", "Тайлбар" гэсэн бүрэлдэхүүн хэсгээс бүтнэ.

2.1.2. "Ерөнхий мэдээлэл"-ийн хэсэгт хяналтын хуудасны код, нэр, хяналт шалгалт хийсэн огноо, шалгуулагч иргэн, хуулийн этгээд болон объектын нэр, хяналтын хуудсаар тогтоогдсон хууль сахин мөрдөлтийн хувь, эрсдэл үүсэх магадлалын талаарх мэдээллийг багтаасан байна.

2.1.3. "Тусгай тэмдэглэл"-ийн хэсэгт шаардлагатай тохиолдолд тухай хяналт шалгалтын чиглэл, хамрах хүрээ, байгууламж, объектын зэрэглэл, давхарын болон ажилчдын тоо гэх мэт бусад мэдээллийг багтаана.

2.1.4. Энэхүү аргачлалын 2.1.2-т заасныг хэрэгжүүлэхдээ хяналтын хуудсанд гал түймрийн хувь, эрсдэл үүсэх магадлалыг тогтоохгүй байж болно.

2.1.5. "Хяналт шалгалтын асуултууд, үнэлгээ"-ний хэсэг нь гамшиг, гал түймрийн аюулаас хүний амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгө, хүрээлэн буй орчныг хамгаалах зорилгоор хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, тэдгээрийг үндэслэн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр, холбогдох стандарт, техникийн норматив, дүрэм, журам, заавар, дэглэмийн биелэлтийг хангуулах

асуултуудаар шалгуулагч иргэн, хуулийн этгээдийн хяналтын хуудсаар авсан нийт оноог тэмдэглэх хэсгээс тус тус бүрдэнэ.

2.1.6. Энэхүү аргачлалын 2.1.5-т заасныг хэрэгжүүлэхдээ гал түймрийн улсын хяналтын хуудсанд оноогоор дүгнэхгүй байж болно.

2.1.7. "Баталгаажуулалт"-ын хэсэг нь улсын хяналтын байцаагч болон тухай иргэн, хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтны нэр, албан тушаал, тэмдэг, гарын үсгээс тус тус бүрдэнэ.

2.1.8. "Тайлбар"-ын хэсэг нь хяналт шалгалтын баталгаажуулалтыг эс зөвшөөрсөн тухай шалгуулагч иргэн, хуулийн этгээдийн талаарх тэмдэглэл байна.

2.1.9. ажлын хэсэг нь энэхүү аргачлалын 2.1.2-т заасан хэсгийг боловсруулахдаа дараах шаардлагуудыг баримтална. Үүнд:

а. Гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналт шалгалтыг явуулахдаа тухайн шалгуулагч иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаа, технологийн дараалал бүрт эрсдэл /ерөнхий, нарийвчилсан/-ийн үнэлгээ хийсэн байдал, гамшиг, аюулт үзэгдэл, осол, эрсдэлийг бууруулахад чиглэсэн хяналт шалгалтын асуултуудыг хэд хэдэн бүлэг болгон багцлан боловсруулна.

б. Гал түймрээс урьдчилан сэргийлэх галын аюулгүйн зай хэмжээ, барилгын дотуур усан хангамж, автомат, тоног төхөөрөмж, утаа зайлуулах систем, холбоо дохиолол гэх мэт чиглэлээр шалгуулагч иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааны онцлог тус бүрээр гаргана.

в. Хяналт шалгалтын асуултууд нь хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг "тийм, үгүй, хамаарахгүй" гэсэн хариултаар үнэлэх бололцоотой байх ба "тийм" гэдэг хариулт нь "тийм, бий, нийцэж байна, хангалттай" гэсэн утгыг илэрхийлэх, "үгүй" гэдэг хариулт нь "үгүй, байхгүй, нийцэхгүй байна, хангалтгүй" гэсэн утгыг илэрхийлэх, "хамаарахгүй" гэсэн хариулт нь "хуулиар шаардахгүй" гэсэн утгыг илэрхийлэх агуулгад нийцүүлнэ.

г. Шалгуулагч иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэл, үйлчилгээ, объект хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа тохиолдолд батлагдсан "0" оноог өгөх боломжтойгоор асуултуудыг боловсруулна.

д. Шалгуулагч иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэл, үйлчилгээ, техник, төхөөрөмж, барилга, байгууламж нь хууль тогтоомж, стандарт, норм, нормативын шаардлагыг хангаагүй эсхүл дутуу хангасан тохиолдолд эрсдэл үүсэхэд шууд нөлөөлөх байдлыг харгалзан асуулт бүрт батлагдсан онооны аль тохирохыг онооно.

е. Хяналтын хуудасны асуултуудыг бөглөж дууссаны дараа шалгуулагч иргэн, хуулийн этгээдийн хууль сахин мөрдөлтийн хувийг гаргахдаа шаардлага хангасан үнэлгээтэй асуултын тоог нийт хяналтын хуудасны асуултын тоонд харьцуулж тооцохоор, эрсдэл үүсэх магадлалыг шаардлага хангаагүй онооны нийлбэрийг нийт хяналтын хуудасны оноонд харьцуулж тооцохоор боловсруулна.

ё. Хяналтын хуудасны нийт онооны 50 буюу түүнээс дээш хувьтай тэнцэх оноо авсан бол "эрсдэл үүсэх магадлал их", 30-49 хувьтай тэнцэх оноо авсан бол "дунд", 29 буюу түүнээс бага хувьтай тэнцэх оноо авсан бол "эрсдэл үүсэх магадлал бага" гэсэн ангилалд хамааруулахаар байна.

ж. Гал түймрийн улсын хяналтын хуудас хууль сахин мөрдөлтийн хувь, эрсдэлийн магадлалыг оноогоор тооцохгүйгээр асуултууд байж болно.

## 2.2. Хяналтын хуудсанд тавих шаардлага

2.2.1. хяналтын хуудас нь тухайн шалгуулагч иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны чиглэлээс шалтгаалж хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд аюул, сөрөг нөлөөлөл үзүүлж

болзошгүй хүчин зүйлс бүхий асуултуудаас бүрдсэн байна.

2.2.2. шалгуулагч иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэл, үйлчилгээний онцлог, хяналтын чиглэлээс хамаарч хяналтыг чиглэл бүрээр хоорондын давхцалгүйгээр хяналт шалгалт хийх хяналтын хуудсыг боловсруулна.

2.2.3. хяналтын хуудас нь хууль, дүрэм, журам, стандартаар заасан шаардлагуудыг шалгуулагч иргэн, хуулийн этгээдэд ойлгомжтой, энгийн хэл найруулгаар боловсруулсан байна.

2.3. Хяналтын хуудсыг боловсруулах аргачлал:

2.3.1. хяналтын чиглэл, дэд чиглэлээр хэдэн төрлийн хяналтын хуудас боловсруулах шаардлагатайг төлөвлөж, хяналтын хуудсыг кодлоно.

2.3.2. тухайн нэг хяналтын хуудсаар хийх хяналт шалгалтад хамаарах хууль тогтоомжийн үндэсний болон олон улсын стандартуудын нэрсийг жагсааж, сан бүрдүүлнэ.

2.3.3. хууль тогтоомжоос тухайн үйл ажиллагааг шалгахад хамаарах зүйл, заалтуудыг ялгаж жагсаан бичнэ.

2.3.4. тухайн хуулийн заалтыг хэрэгжүүлээгүйгээс хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөлөл үүсгэж болзошгүй асуудалд чиглэсэн хуулийн заалтуудыг ялгаж авна.

2.3.5. хууль, дүрэм, журам, стандартаар заасан шаардлагуудыг тодорхой, хэмжигдэхүйц, энгийн байдлаар томъёолж, асуулт хэлбэрт шилжүүлнэ. Асуулт нь "тийм", "үгүй" хариултын аль нэгийг шууд өгөх бололцоотой байна.

2.3.6. хяналт шалгалтын асуултуудыг үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаа, технологийн дарааллаар бүлэг болгон багцалж, дэд гарчиг өгөөд, эрсдэл үүсгэхэд шууд нөлөөлөх магадлалтай асуудлаас бага руу эрэмбэлж жагсаана.

2.3.7. асуулт бүрт эрсдэл үүсгэхэд шууд нөлөөлөх байдлыг харгалзан 50 хүртэл онооны аль тохирохыг өгнө.

2.3.8. хяналтын хуудасны "Хяналт шалгалтын асуултууд, үнэлгээ" хэсэгт асуултуудыг онооны хамт байрлуулна.

2.3.9. Энэхүү аргачлалын 2.3.8-д заасныг хэрэгжүүлэхдээ гал түймрийн улсын хяналтын хуудсанд оноог байрлуулахгүй байж болно.

2.3.10. боловсруулсан хяналтын хуудсыг иргэн, хуулийн этгээд, улсын байцаагчдын төлөөлөлд хэлэлцүүлж, засан сайжруулна.

2.3.11. хяналтын хуудсыг хяналт шалгалтад туршиж, засаж сайжруулна.

2.3.12. хяналтын хуудсыг баталгаажуулна.

#### Гурав. Хяналтын хуудсыг баталгаажуулах

3.1. Дараах шалгуурыг хангасан тохиолдолд хяналтын хуудсыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга бөгөөд гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын ерөнхий байцаагчийн тушаалаар баталгаажуулна. Үүнд:

3.1.1. хяналтын хуудсыг улсын байцаагчдын төлөөлөл болон Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын гамшгийн шуурхай удирдлага болон гал түймэртэй тэмцэх асуудал эрхэлсэн бүтцийн нэгжийн хүрээнд 2-оос доошгүй удаа хэлэлцүүлж, засан сайжруулсан байх;

3.1.2. хяналтын хуудсыг 3-аас доошгүй шалгуулагч иргэн, хуулийн этгээдэд хяналт шалгалтаар туршиж, засан сайжруулсан байх;

3.1.3. энэ аргачлалд заасан хяналтын хуудасны бүтэц, шаардлага, боловсруулах дарааллыг баримталсан байх.

Дөрөв. Хяналтын хуудсанд нэмэлт, өөрчлөлт оруулах

4.1. Хяналтын хуудасны хяналт шалгалтын асуултууд нь эхний ээлжинд дэлгэрэнгүй байж болох ба хяналтыг хэрэгжүүлэх салбар, нэгжээс, шалгуулагч этгээд аль аль нь хяналтын хуудсыг ашиглаж хэвшсэний дараа сайжруулж, хураангуйлж болно.

4.2. Хяналт шалгалтын явцад шалгуулагч иргэн, хуулийн этгээдээс хяналтын хуудсыг өөрчлөх санал гаргасан тохиолдолд тухайн хяналтыг хэрэгжүүлэх төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын салбар, нэгжээс хянаж, үндэслэл бүхий сайжруулах саналыг боловсруулж, Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын гамшгийн шуурхай удирдлага болон гал түймэртэй тэмцэх асуудал эрхэлсэн бүтцийн нэгжид ирүүлнэ.

4.3. Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын гамшгийн шуурхай удирдлага болон гал түймэртэй тэмцэх асуудал эрхэлсэн бүтцийн нэгжээс хяналтын хуудсыг өөрчлөх болсон үндэслэл, нэмэлт өөрчлөлтийн төслийг хянаж үзэж үндэслэлтэй тохиолдолд ажлын хэсэг томилон ажиллуулж, тус хяналтын хуудас боловсруулах аргачлалын дагуу боловсруулж, баталгаажуулна.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын  
2022 оны 6 дугаар сарын 10 ны өдрийн  
тушаалын хоёрдугаар хавсралт



№0.0 .....  
**ХЯНАЛТЫН ХУУДАСНЫ ЕРӨНХИЙ ЗАГВАР**

**1.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:**

Хяналтыг хэрэгжүүлэх салбар, нэгж:		
Шалгуулагч этгээдийн нэр:		
Регистрийн дугаар:		
Объектын нэр, хаяг, солбилцол:		
Байгуулагдсан огноо:		
Үйл ажиллагааны чиглэл:		
Дарга, захирал /иргэн, эрхлэгч/-ын нэр, холбоо барих утасны дугаар:		
Хяналт шалгалт хийсэн огноо:	Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийсэн огноо:	Гүйцэтгэлийн хяналт шалгалт хийсэн огноо:
Шаардлага хангасан асуултын тоо:	/...../	/...../
Шаардлага хангаагүй нийт огноо:	/...../	/...../
Хууль сахин мөрдөлтийн хувь:	/...../	/...../
Эрсдэл үүсэх магадлалын хувь:	/...../	/...../
Эрсдэл үүсэх магадлал:	/ их, дунд, бага /	/ их, дунд, бага /

**2.ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АСУУЛТУУД, ҮНЭЛГЭЭ:**

№	Хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартын нэр, зүйл, заалт	Асуултууд	Батлагдсан огноо		Авсан огноо	Гүйцэтгэлийн хяналт шалгалт
			Шаардлага хангасан	Шаардлага хангаагүй		
	1	2	3	4	5	6
1						
2						
3						
Нийт огноо						

**3.БАТАЛГААЖУУЛАЛТ:**

Хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн улсын байцаагчийн албан тушаал, нэр, гарын үсэг, тэмдэг	Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хүлээн зөвшөөрсөн; шалгуулагч этгээдийн эрх бүхий албан тушаалтаны нэр, гарын үсэг, тэмдэг	Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хүлээн зөвшөөрсөн; шалгуулагч этгээдийн эрх бүхий албан тушаалтаны нэр, гарын үсэг, тэмдэг
/ албан тушаал /	/ албан тушаал /	/ албан тушаал /
/ овог, нэр /	/ овог, нэр /	/ овог, нэр /
/ гарын үсэг, тэмдэг /	/ гарын үсэг, тэмдэг /	/ гарын үсэг, тэмдэг /

**ТАЙЛБАР:**

.....  
.....  
.....